

**“ӨРХИЙН ТАРИАЛАЛТЫГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРИЙН  
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
/Жилийн эцсийн байдлаар/**

Зорилго		Өрхийн тариаланчдыг дэмжих замаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, аймгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг жилийн турш, тогтвортой хангахад оршино.					
Үйл ажиллагааны чиглэл		Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл					
Зорилт 1. Төмс, хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог хөгжүүлэх							
№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт, хувь
1.	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл шинээр эрхлэх, үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд зээлийн бодлогоор дэмжих	Жилдээ	-	Зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо, (сая.төг)	22 иргэн 459.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	20 хүртэл	Засгийн газраас олгосон хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч 16 иргэн 474.6 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн, 1 иргэн 35.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсанаар 22 ажлын байр хадгалагдсан. Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сангаас газар тариалан эрхлэх чиглэлээр 2 иргэн 30.0 сая төгрөгийн зээл авснаар 4 ажлын байр хадгалагдаж, нийт 19 иргэн 504.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авснаар 26 ажлын байр хадгалагдсан байна. Хэрэгжилт 95%
2.	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг төрөөс үзүүлж буй дэмжлэг, урамшуулалд хамруулах боломжийг бүрдүүлэх	Жилдээ	-	Дэмжлэг, урамшуулалд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	500 өрхийг үрийн дэмжлэгт хамруулсан.	500 өрх	Орон нутгийн төсвөөс 40.0 сая төгрөгийг батлуулан хөтөлбөрт хамрагдсан Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрхөд 5 төрлийн үрийн багц олгож, төмс, хүнсний ногоо тариалах гарын авлагаар ханган, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй

							<p>нөхцөлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг орон нутагт татан авч, сумын Засаг даргын Тамгын газраар дамжуулан нийт 5 аж ахуйн нэгж, 230 өрхөд олгосон. Хүнсний ногооны тариалалтад шаардлагатай үрийн 30 хувийг дэмжлэгээр олгосноор 730 өрх 8 га талбайд төмс, 140 га талбайд хүнсний ногоо тариалж өрхийн хэрэгцээгээ хангаж байна.</p> <p>Хэрэгжсэн 100%</p>
<p>Зорилт 2. Төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийн хүрсэн түвшинг тогтворжуулан, хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжих, таримлын нэр төрлийг олшруулах, нэгж талбайгаас хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн хүн амыг төмс, хүнсний ногоогоор тогтвортой хангах</p>							
3.	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх	Жилдээ	-	Хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний эзлэх хувь	4.7 хувь	4.7 хувь	<p>Улсын төсвийн хөрөнгөөр “Үйлдвэрлэгч баг” төслийн хүрээнд 90 ширхэг, “Шинэ хөдөө-Орхон” төслийн хүрээнд 10 ширхэг, нийт 100 ширхэг хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид олгосноор хүлэмжийн талбай 1.2 га талбайгаар нэмэгдсэн.</p> <p>Энэ онд хүлэмжийн тариалалт 5.1 га талбайд хийж, 304 тонн ургац хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургацын эзлэх хувь 3.2 байна. Энэ нь тайлант онд хүлэмжийн ургац өмнөх оноос 55 тонноор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолын хүрээнд өвлийн хүлэмжийн аж ахуй эрхлэгч 9 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 2200 м.кв хүлэмжийг цахилгааны хөнгөлөлтөд хамруулж байна.</p> <p>Хэрэгжилт 100 %</p>
4.	Нийлэг хальсан хүлэмж, ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулах	Жилдээ	40.0	<p>1. Хүлэмж (ширхэг)</p> <p>2. Үр (кг)</p>	1. 27 ширхэг хүлэмж	1. 20-оос доошгүй хүлэмж	<p>Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Хан төгөл хайлааст” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан төмсний үр 20 тн, хүнсний</p>

					2. 1 тонн төмс, хүнсний ногооны үр олгосон.	2. 2 тн ногооны үр	ногооны үр 90 кг-ийг олгох ажлыг зохион байгуулсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг тариаланчдад олгосон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Үйлдвэрлэгч баг” төслийн хүрээнд 90 ширхэг, “Шинэ хөдөө-Орхон” төслийн хүрээнд 10 ширхэг, нийт 100 ширхэг хүлэмжийг иргэдэд олгох ажлыг зохион байгуулсан. Хэрэгжсэн 100%
5.	Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх замаар ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэн аймгийн хүн амыг орон нутагт тариалсан төмс, хүнсний ногоогоор ханган ажилласан байна.	Жилдээ	-	Төмс, хүнсний ногооны хангамж (хувь)	Төмс 82 хувь Хүнсний ногоо 91.6 хувь	Төмс 85 хувь, Хүнсний ногоо 75 хувь	Тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, үржил шимийг сайжруулах зорилгоор тариалангийн талбайг хашаажуулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд нийт 185 км хашаагаар 3800 га тариалангийн талбайг хашиж хамгаалсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулахаар төлөвлөж Жаргалант сумын Бөөн бургастад 3.6 км хашаа шинээр барьж, 36-р тоцикт 1.5 км хашаа сэргээн засварласан. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 49 иргэний эзэмшлийн 51 га талбайг хашиж хамгаалсан. Тайлант онд үр тариа 3904 га талбайгаас 10892 тн буюу га-аас 28 цн ургац үүнээс улаан буудай 3805 га талбайгаас 10752 тн буюу 28 цн ургац, төмс 145 га талбайгаас 1628 тн буюу га-аас 112 цн, хүнсний ногоо 455.2 га талбайгаас 9520

						<p>тн буюу га-аас 209 цн, тэжээлийн ургамал 287 га талбайгаас 1122 тн буюу га-аас 39 цн, тосны ургамал 821 га талбайгаас 300 тн буюу га-аас 3.7 цн ургац тус тус хураан авсан.</p> <p>Ургац хураалтын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 90%</p>
6.	<p>Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем болон статистик мэдээлэлд хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тарималын нэр төрлөөр нь, тариалалт, хураалтын мэдээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүрээр хамруулах.</p>	Жилдээ	-	<p>1.Тариалсан талбай (га)</p> <p>2.Хураан авсан ургац (цн)</p>	<p>Төмс 273 га, ургац 3072 тн</p> <p>Хүнсний ногоо 503 га, ургац 7317 тн</p>	<p>Төмс 270 га, ургац 3240 тн</p> <p>Хүнсний ногоо 503 га, ургац 6038 тн</p> <p>Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем plant.mofa.gov.mn цахим системд аймгийн хэмжээнд 468 нэгж талбарын 5239 га тариалангийн талбай, 308 иргэн, 28 аж ахуйн нэгж бүртгүүлсэн. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн 2022 онд хураан авсан ургацаас цахимаар 175 удаагийн урамшууллын хүсэлт илгээснээр хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчид 460.0 гаруй сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан. Энэмонд plant.mofa.gov.mn цахим системд 30 аж ахуйн нэгж, 328 иргэнийг тариаланчаар бүртгэж тэдгээрийн 481 талбарын 5279.4 га талбайг баталгаажуулж 2022 оны ургацаас 175 удаагийн урамшууллын хүсэлтийг цахимаар илгээснээр 900.0 сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан. Тайлант хугацаанд төмс 145 га талбайд тариалж 1628 тн ургац, хүнсний ногоо 455 га талбайд тариалж 9520 тонн ургац хураан авсан нь төлөвлөгөөт ургацаар тооцоход хүнсний ногооны ургац 57 хувиар өсч, төмс 49 хувиар буурсан байна</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 90%</p>

Зорилт 3. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэх, төрөлжсөн зах, худалдааны төвийг дэмжин хөгжүүлэх.

7.	Төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь, агуулах барих иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих	Жилдээ	3400.0	Зоорь, агуулахын багтаамж (тонн)	6548 тн багтаамжтай 161 ширхэг зоорь	500 тн-оор нэмэгдүүлэх	<p>Аймгийн хэмжээнд нийт 6548 тн багтаамжтай 161 ширхэг зоорийг ашиглаж байна. Энэ онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорь баригдаж байгаа бөгөөд 2024 онд ашиглалтад орно. Тус зоорь ашиглалтад орсноор стандартын шаардлага хангасан төмс, хүнсний ногооны зоорины багтаамж 500 тн-оор нэмэгдэнэ.</p> <p>Зооринд шаардагдах тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд санал хүргүүлснээр Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих” төслөөс манай аймагт Сэрээт өргөгч 1 ширхэг, модон хайрцаг 300 ширхэг, хуванцар хайрцаг 200 ширхгийг олгосон.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 90%</p>
8.	Төмс, хүнсний ногооны борлуулалтыг бодлогоор дэмжин ажиллах	III, IV улирал	-	Аж ахуйн нэгж, иргэний тоо	3 аж ахуйн нэгж, 2 хоршоо 14 байгууллагад нийлүүлэлт хийсэн.	3 аж ахуйн нэгж	<p>Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, “BEST” хөтөлбөртэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТӨҮГ, томоохон аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд 2023 онд тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 3 аж ахуйн нэгж, 3 иргэн Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т 497.0 сая төгрөгийн төмс, хүнсний ногоо нийлүүлсэн. Мөн “Эрдэнэт хивс” ХХК, Шунхлай ШТС, “Ачит Ихт ХХК-д</p>

							<p>төмс, хүнсний ногоогоо борлуулан ажиллаж байна.</p> <p>Баясгалант Бат-Очир ХХК, Үрт Ундрам ХХК, БЛГЯ хоршоо нь нийт 24 цэцэрлэг болон 16 сургуулийн үдийн хоолны ногоог гэрээгээр нийлүүлж, Эрүүл мэндийн байгууллага, хоол үйлдвэрлэлийн газарт 12 иргэн, 5 аж ахуйн нэгж өөрийн тариалсан төмс, хүнсний ногоог нийлүүлэн ажиллаж байна. Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулсан “Үндэсний үйлдвэрлэл-Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн арга хэмжээнд Жаргалант сумын 3 тариаланчийг дэмжин оролцуулсан.</p> <p>Хэрэгжсэн 100%</p>
Зорилт 4. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах замаар чадавхийг сайжруулах							
9.	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг техник технологийн, хөдөө аж ахуйн зохистой дадал олгох сургалт, семинар, туршлага судлах ажилд хамруулах	Жилдээ	-	Сургалтад хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	4 удаагийн сургалтад 320 иргэн хамрагдсан.	3 удаа 120 иргэн хамруулах	<p>Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг мэдлэг олгох дараах сургалтуудад хамруулсан. Үүнд:</p> <p>-Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем болох <a href="http://plant.mofa.gov.mn">plant.mofa.gov.mn</a> цахим системд газар тариалангийн салбарын мэдээ, мэдээллийг оруулах, баталгаажуулах,</p> <p>-“Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг танилцуулах, урамшуулал, дэмжлэгт хамрагдахад системийг хэрхэн ашиглах, дэмжлэг, урамшууллын материалыг цахимаар хэрхэн бүрдүүлэх</p> <p>-Хөрсний үржил шим сайжруулах, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо</p>

						<p>хэрэглэсэн иргэн, хуулийн этгээдэд татаас олгох баримт бичгийн танилцуулга</p> <p>-Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмын танилцуулга</p> <p>Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг хийн мэдээлэл оруулахад зөвлөн тусалсан. Дээрх сургалт, арга хэмжээнд 2 сумын 180 гаруй тариаланчдыг хамруулсан.</p> <p>Хэрэгжсэн 100%</p>
Биелэлтийн дундаж хувь						96.1%

ХЯНАСАН: ҮХҮА-Ы ДАРГА Г.БАТДЭЛГЭР

ТАЙЛАН БИЧСЭН: ҮХҮА-Ы ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНИК ТЕХНОЛОГИ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТ Б.ОЮУНТУНГАЛАГ